



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 1/323

Зуунмод

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
ажиллах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6 “а”, “б”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 1.6, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоолын 1, 3, мөн 2021 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдварт /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 171 дүгээр тушаалаар батлагдсан “Давтлага зохион байгуулах заавар батлах тухай” тушаалын 4, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Түр журам батлах тухай” тушаалын 2, 4, “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын 1.1, 2, 3, 6, 7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэн хугацаанд төрийн байгууллага, хуулийн этгээд, хүний үйл ажиллагааны зохицуулалтыг батлагдсан журамд заасны дагуу зөв зохион байгуулж, халдвартархахаас урьдчилан сэргийлэх, халдвартархалт нэмэгдсэн тохиолдолд тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), аймгийн Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар) нарт даалгасугай.

2. Коронавируст халдварт /Ковид-19/-ын эсрэг вакцинжуулалтын ажлыг аймгийн хэмжээнд эрчимжүүлж, вакцинжуулалтад иргэдийг хамруулах ажлыг идэвхжүүлэх, иргэд олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Бүртгэлийн цахим системийн QR код байршуулаагүй, халдварт хамгааллын дэглэм, холбогдох дүрэм журам мөрдөөгүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т чиглэл болгосугай.

4. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар (Р.Ундралхбаяр), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг) нарт даалгасугай.

5. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ыг иргэд, олон нийтэд мэдээлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга бөгөөд Онцгой комиссын орлогч (Н.Төмөрбаатар), Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг) нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБААТАР

